



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 01 өдөр

Дугаар 8/343

Мандалговь

Галт зэвсгийн тооллого
явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн "е", 26.1.6-ын "а", "л", Хууль зүйн сайдын 2015 оны A/220 дугаар тушаалаар батлагдсан "Галт зэвсгийн тооллого явуулах журам"-ын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Иргэн хуулийн этгээдийн өмчлөлд байгаа галт зэвсгийн 2019 оны тооллогыг аймгийн хэмжээнд 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

Хоёр. Нутаг дэвсгэртээ иргэний болон харуул хамгаалалтын зориулалтаар ашиглагдаж байгаа галт зэвсэг, түүнтэй адилтгах хэрэгслийн тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг мэргэжлийн байгууллага, албан тушаалтанг оролцуулан томилж, удирдлага, зохион байгуулалтаар ханган, бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэхийг сумдын Засаг дарга нарт, ажлын хэсгийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандад О.Амарсанаа), Татварын хэлтсийн дарга (М.Туяацэцэг) нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Галт зэвсгийн тооллого явуулах ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд сурталчилж, иргэний болон харуул хамгаалалтын чиглэлээр ашиглаж байгаа галт зэвсэг, түүнтэй адилтгах хэрэгслийг галт зэвсгийн улсын тооллогод бүрэн хамруулахыг аймгийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, сум, багийн Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190973